



ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

WEEKLY FOCUS



БРОКЕРИЙН ХЭЛТЭС

АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

АРИЛЖАА СУДАЛГААНЫ ХЭЛТЭС



АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС /S&P500/

Хураангуй: Өнгөрсөн долоо хоногт S&P500 индексийн ханш 3,593.25 ам.доллар дээр нээгдэж, дээд ханш 3,820.00 ам.доллар, доод ханш 3,571.75 ам.долларт хүрч эцэстээ 3,650.75 ам.доллар дээр хаагдлаа.



Ханшийн хөдөлгөөнд дараах хүчин зүйлс нөлөөлөв:

- ✓ Өнгөрсөн 9-р сард АНУ-ын Аж үйлдвэрийн салбарын худалдан авалт хариуцсан менежерүүдийн индекс [PMI] 50.9 болж буурснаар эдийн засгийн 12%-ийг эзэлдэг тус салбарын өсөлт удааширч байгааг харуулав.
- ✓ Хөрөнгө оруулагчдын хувьд тус индексийн [PMI] бууралт ХНС-ын бодлогод нөлөөлж улмаар бодлогын хүүг өндөр хувь хэмжээгээр нэмэгдүүлэх магадлал буурах хүлээлттэй байсан юм. Тус мэдээллийн дараа 2 хоног дараалж хөрөнгийн биржийн индексүүд өсөлттэй арилжаалагдсан байна.
- ✓ АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн өндөр албан тушаалтнууд эдийн засгийн тоо мэдээ гарсантай холбоотойгоор өөрсдийн байр суурийг илэрхийлсэн байна. Тухайлбал Chicago-ын ХНС-ын тэргүүн Charles Evans “ХНС цаашид мөнгөний хатуу бодлогоо үргэлжлүүлэх хэрэгтэй, улам ахих хэрэгтэй” гэж хэлээд энэ оны төгсгөлд бодлогын хүүг 4.5%-4.75% хүртэл өсгөх нь зүйтэй гэжээ. [Бодлогын хүүгийн одоогийн түвшин 3%-3.25% тай байна.]
- ✓ Elon Musk болон Twitter компанийн удирдлагууд компанийн худалдан авалттай холбоотойгоор тохиролцоонд хүрсэн гэж эх сурвалжууд мэдээлжээ. Улмаар хувьцааны ханш долоо хоногийн дотор 15%-аар өссөн байна.



S&P 500 ИНДЕКСИЙН ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ

4Hour ханшийн график :



✓ S&P 500 индекс нь сүүлийн 2 жилийн fair price буюу бодит үнэ цэнийн Value Area Low гэх ёроолын түвшинд ирээд байна.

Daily ханшийн график :





БНХАУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС/HSI

Хураангуй: Өнгөрсөн долоо хоногт HSI индексийн ханш 17,050 хонгконг доллар дээр нээгдэж, дээд ханш 18,164 хонгконг доллар, доод ханш 16,906 хонгконг долларт хүрч эцэстээ 17,740 хонгконг доллар дээр хаагдлаа.




Ханшийн хөдөлгөөнд дараах хүчин зүйлс нөлөөлөв:

- ✓ АНУ-ын эдийн засгийн таагүй мэдээ хөрөнгийн зах зээлд эерэг мэдээ болон хувирч байна. Энэ нь ХНС-ын бодлогын хүү өндөр хувь хэмжээгээр хурдтай өсөж буйтай холбоотой юм. Хонг Конгын зах зээл азийн бусад зах зээлийн адил АНУ-ын арилжааны өдрийн хөдөлгөөнийг дагах хандлагатай байна. Улмаар өнгөрсөн долоо хоногийн эхэнд АНУ-ын зах зээлийн адил 2 өдөр дараалан өсөж сүүлийн өдрүүдэд уналттай арилжаалагдсан байна.
- ✓ Өнгөрсөн лхагва гарагт Goldman Sachs Хонг Конгын орон сууцны үнэ цаашид үргэлжлүүлэн унана гэж мэдэгджээ. Энэ нь зээлийн хүү өсөж орон сууцны эрэлт буурсантай холбоотой юм. Тус мэдээ гарснаар Хонг Конгын үл хөдлөхийн компаниудын хувьцааны ханш унасан байна.
- ✓ Хятадын хөрөнгийн зах зээлийн уналт үргэлжилж, юанийн ханш ам.долларын эсрэг суларч байгаа энэ үед хөрөнгө оруулагчид Хятадын зах зээлийг үргэлжлүүлэн унана гэж BSA Research судалгааны үр дүнгээ танилцуулсан байна. Судалгаанд оролцсон шинжээчдийн 60% нь Хятадын хөрөнгийн зах зээлийг 12-18 сарын хугацаанд үргэлжлүүлэн унана гэж харж байна гэжээ.



HANG SENG ИНДЕКСИЙН ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ

Daily ханшийн график :



- ✓ HSI нь сүүлийн 16-н жил 19,000-25,000 HKD хооронд тогтворжилтод арилжаалагдаж байсан бөгөөд энэхүү бүсээ доош сэтлээд байна.
- ✓ Энэхүү бүсээ сүүлд 2008 болон 2011 онд доош сэтэлж байсан байна.

Weekly ханшийн график :





АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Голлох мэдээллүүд:

- ✓ Өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт АНУ-д шинээр бий болсон ажлын байрны [NFP] тоон үзүүлэлт гарсан байна. Шинжээчдийн таамаглалаар шинээр 250,000-н ажлын байр бий болох хүлээлттэй байсан ч бодит тоон үзүүлэлт 263,000-тай гарсан байна. Улмаар хөрөнгийн захын индексүүд нэг өдрийн дотор өндөр хувь хэмжээгээр унасан байна. [DJIA -2.11%, S&P 500 -2.8%, Nasdaq -3,8%]
- ✓ Дээрх тоон мэдээ үзүүлэлттэй хамт гарсан АНУ-ын 9-р сарын ажилгүйдлийн түвшин 3.5%-д хүрч буурав. Энэхүү тоон үзүүлэлт нь 1969 оноос хойших ажилгүйдлийн түвшний хамгийн бага хувь хэмжээ бөгөөд АНУ-д хөдөлмөрийн зах зээл хүчтэй байгааг илтгэж байна. [Өнгөрсөн 8-р сард ажилгүйдлийн түвшин 3.7%-тай байсан бөгөөд Dow-ын судалгаанд оролцсон шинжээчид өөрчлөлтгүй буюу 3.7%-тай гарна гэж таамаглаад байсан юм.]

ОНЦЛОХ ХУВЬЦАА

Twitter Inc (TWTR) - NYSE



- ✓ Ханш сүүлийн 1 жилийн хугацаанд 33.00-51.50 ам.долларын хооронд тогтворжилтод арилжаалагдаж байгаа бөгөөд сүүлийн долоо хоног тогтворжилтийн оройн бүсээс эсэргүүцэл авч уналт үзүүлээд байна.



БНХАУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Голлох мэдээллүүд:

- ✓ Хонг Конгын хөрөнгийн захын хувьцаанууд өнгөрсөн лхагва гарагт 5 гаруй хувийн өсөлттэй арилжаалагдсан бөгөөд хүчтэй эсэргүүцэгч бүсээс [техник анализаар] эсэргүүцэл аван унасан байна.
- ✓ БНХАУ-д цар тахлын хөл хорио үргэлжилж “тэг ковид” бодлогын улмаас эдийн засаг агшиж байна. Энэхүү эдийн засгийн таагүй орчин хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлж байгаан дээр юанийн ханш ам.долларын эсрэг суларч байгаа нь нөхцөл байдлыг улам хурцатгаж байна.
- ✓ Томоохон хөрөнгө оруулагчид болон сангууд ирэх амралтын өдрүүдэд болох БНХАУ-ын коммунист намын 20-р их хурлаас гарах шийдвэрийг хүлээж байна. [10.16]

ОНЦЛОХ ХУВЬЦАА

ICBC (1398)- НККХ



- ✓ ICBC нь анх IPO хийснээс хойш буюу сүүлийн 16-н жил 3.84-6.81 HKD хооронд тогтворжилтод арилжаалагдаж байгаа бөгөөд сүүлийн 4-н жил уналт үзүүлж ёроолын бүс дээр ирээд байна.
- ✓ Энэхүү ёроолын бүс дээр сүүлд 2008, 2011, 2016 онуудад арилжаалагдаж байсан байна.



ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

ӨНӨӨДӨР МОНГОЛД: ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ ИМПОРТЫН 2-3 САРЫН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ТҮВШИНД БАЙНА


- Монгол Улсын гадаад валютын албан нөөц есдүгээр сард 2.8 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн харьцуулахад 33.16 хувиар буураад байна. Импортоор авч буй бараа, үйлчилгээний өртөг, зардал нэмэгдсэнээр төлбөрийн тэнцлийн алдагдал даамжирч, гадаад валютын нөөц буурахад нөлөөлж байгаа аж. Төлбөрийн тэнцлийн алдагдал оны эхний найман сарын байдлаар 1.5 тэрбум ам.доллар хүрээд байна.

ӨНӨӨДӨР МОНГОЛД: БОГД БАНК ХК-ИЙН ЭЭЛЖИТ БУС ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХУВЬЦААНЫ ХУВААЛТЫН АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭНЭ

- "Богд Банк" ХК нь 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах гэж буй зарыг олон нийтэд зарласан бөгөөд хурлаар хэлэлцэх асуудалд дүрмийн сангийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүйгээр хувьцааг хуваах хувьцааны тоо ширхэгийг 20 дахин өсгөж, хувьцааны нэрлэсэн үнийг мөн хэмжээгээр бууруулах асуудлыг хэлэлцэх тухай тусгажээ.

ӨНӨӨДӨР МОНГОЛД:МОНОС ХҮНС ХК-ИЙН НОГДОЛ АШИГ ТАРААЛТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

- "Монос хүнс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №27/02 тоот тогтоолоор 2021 оны цэвэр ашгаас нийт 817,700,856 төгрөг буюу нэгж хувьцаанд 2 төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулж эхэлсэн байна.





ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

ӨНӨӨДӨР МОНГОЛД: МОНГОЛ УЛС FTSE RUSSELL-Н ХӨГЖИЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ АНГИЛАЛД ОРЛОО


- Олон улсад хөрөнгийн зах зээлийн индексийг тодорхойлогч Их Британийн FTSE Russell компани нь улс орнуудын хөрөнгийн зах зээлийг олон төрлийн техник шалгуураар үнэлгээ өгдөг бөгөөд 2022 оны есдүгээр сарын 29-ний өдөр FTSE Russell группээс Хөгжиж буй зах зээл (Frontier Market) ангилалд албан ёсоор орсон талаар мэдээллээ.

ӨНӨӨДӨР МОНГОЛД: МОНГОЛБАНК ЕСДҮГЭЭР САРД 2.4 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

- Монголбанк 2022 оны 9 дүгээр сард 2,416.4 кг үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр 15.0 тонн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1 хувиар өссөн үзүүлэлт байна. Оны эхнээс өссөн дүнгээр Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 1,695.7 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны хэлтэс 1,046.9 кг үнэт металл тус тус худалдан авсан.

ӨНӨӨДӨР МОНГОЛД: МОНОС ХҮНС ХК-ИЙН НОГДОЛ АШИГ ТАРААЛТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

- "Монос хүнс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №27/02 тоот тогтоолоор 2021 оны цэвэр ашгаас нийт 817,700,856 төгрөг буюу нэгж хувьцаанд 2 төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулж эхэлсэн байна.





ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

ӨНӨӨДӨР МОНГОЛД: ТӨРИЙН БАНК ХК НЭМЭЛТЭЭР 5.6 САЯ ШИРХЭГ ХУВЬЦАА ГАРГАСАН

- Төрийн банкны үнэт цаасны зах зээлийн арилжааны нээлт есдүгээр сарын 30-ны өдөр Монголын хөрөнгийн биржид эхэлсэн 10 цагаас эхэлсэн билээ. Үнэт цаасны эхний өдрийн захиалга 100% даван биелж эрэлт өндөртэй байсан тул үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу нийт гаргасан хувьцааны 15 хувийг нэмж гарган захиалгыг хувь тэнцүүлсэн.

ӨНӨӨДӨР БИРЖИД: ТА НЭГ ЖИЛИЙН ХУГАЦААНД 43%-ИЙН ӨГӨӨЖТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙСЭН ҮҮ?

- TOP 20 индексийн багцыг бүрдүүлэгч 20 хувьцаат компаниас 2021.10.01-ээс 2022.10.01-ны хугацаанд хамгийн өндөр ногдол ашгийн өгөөжтэй компанийн хувьцаа нь 7.5%-аар АПУ ХК-ийн хувьцаа байна. Тухайн хугацаанд АПУ ХК нь нэгж хувьцаанд 105 төгрөгийн ногдол ашиг олгосон байна. Харин эзэмших хугацааны өгөөжөөр буюу ногдол ашгийн өгөөж болон ханшийн өсөлтийн өгөөжийн нийлбэр дүнгээр “Талх Чихэр ХК” –ийн хувьцааны өгөөж 42.8%-аар тэргүүлсэн байна.

ӨНӨӨДӨР БИРЖИД: БҮХ ӨНДГӨӨ НЭГ САГСАНД ХИЙЖ БОЛОХГҮЙ

- Диверсификаци гэдэг нь хөрөнгөө олон төрлийн, ялгаатай эрсдэлийн хүчин зүйлээс хамаардаг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах, түгээмэл ашигладаг хөрөнгө оруулалтын стратеги билээ. Хамгийн энгийн хөрөнгөө диверсификаци хийх арга бол ялгаатай салбаруудын компаниудад хөрөнгө оруулах билээ. Гэхдээ зарим хөрөнгө оруулагч нар цөөн салбарыг гүн гүнзгий судалж, тэдгээрээс ашиг олохын тулд мэдлэгээ ашиглах нь оновчтой гэж үздэг

ТӨРИЙН БАНК

590₮
НЭГЖ ХУВЬЦААНЫ ҮНЭ

22.1₮ ТЭРБУМ
НИЙТ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ДҮН

5%
ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БҮЙ ХУВЬ

IPO

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОЛНТ БОЛГО





ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

ӨНӨӨДӨР БИРЖИД. БИРЖИЙН АРИЛЖААНЫ ДҮН ӨМНӨХ САРААС ХОЁР ДАХИН ӨССӨН

• Монголын хөрөнгийн бирж дээр 9 сарын 1-ээс 9 сарын 30-ны нийт 18 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд энэ нь өмнөх сараас хоёр дахин өссөн байна. Ийнхүү өсөхөд Сэндли ББСБ-ийн анхдагч зах зээлийн 10.05 тэрбум төгрөгийн арилжаа нөлөөлсөн байна. Харин 4.2 тэрбум төгрөгийн арилжаа хоёрдогч зах зээл дээр хийгдсэн бөгөөд үүнээс 59.43 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийн арилжаа нь нэгдүгээр ангиллын 20 компанийн хувьцааны арилжааны дүн байна.

ӨНӨӨДӨР БИРЖИД: МОНОС ХҮНС ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН ӨГӨӨЖ БУСАД I АНГИЛАЛЫН ХУВЬЦААТАЙ ОЙРОЛЦОО БАЙНА

• Монос Хүнс ХК-ийн 2022Q2 борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 85.5 хувиар өсөж 13.9 тэрбум хүрэхийн зэрэгцээ нийт ашгийн маржин 79 хувиар өссөн байдалтай байна. Борлуулалтын орлого нэмэгдэж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон үйл ажиллагааны зардлын бууралтын нөлөөгөөр цэвэр ашиг 178 хувь өсөж 1.51 тэрбум болжээ.

ӨНӨӨДӨР БИРЖИД: БОДЬ ДААТГАЛ ХК САЛБАРТАА ЯМАР БАЙР СУУРЬТАЙ БАЙГАА ВЭ?

• Нийт хураамжийн орлогоороо салбартаа 3-т жагсаж байгаа хэдий ч цэвэр хураамжийн орлогоороо МХБ-д бүртгэлтэй компаниудыг тэргүүлж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж 3 нэгж хувиар өсөж 17% болсон нь салбарын дунджаас өндөр байна. Хохирлын харьцаа салбарын дунджаас дээгүүр байгаа бол хосолсон харьцаа салбарын дундажтай ойролцоо үзүүлэлттэй байна.





ТАВАН БОГД КАПИТАЛ

БОЛОМЖОО БОДИТ БОЛГО



БРОКЕРИЙН ХЭЛТЭС

АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

АРИЛЖАА СУДАЛГААНЫ ХЭЛТЭС